

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН  
БАРУУН БҮС ДЭХ ГАЗРЫН 2018 ОНЫ 05 ДУГААР САРЫН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2018 оны 05 дугаар сарын 26

Ховд хот

Монгол Улсын иргэд харилцан зорчих талаар гадаад улсуудтай байгуулсан гэрээ, хэлэлцээр, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Харьяатын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засгийн газрын 2010 оны 338, 339, 340 дүгээр тогтоол болон бусад холбогдох хууль тогтоомжуудыг удирдлага болгон 2018 оны 04 дүгээр сарын 26-ний өдрөөс 2018 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн хооронд албаны үйл ажиллагааг зохион байгуулж ажиллаа.

**НЭГ. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:**

**1.1. Зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааны хүрээнд:**

Тайлант хугацаанд 3 орны 118 гадаадын иргэнд зохих ангилал, зориулалтын визийг олгосон. Үүнд:

- 1 удаагийн орох - 107
- 1 удаагийн гарах- орох – 10
- Олон удаагийн гарах- орох-1

**Алдаатай олгосон визийн засвар:**

Бүгд Найрамдах Казахстан Улсын Астана хот дахь Монгол Улсын Элчин сайдын яамнаас БНКаз.У-ын иргэн Kinoyat Riza /1945.04.01-нд төрсөн, эмэгтэй, N11739332 дугаарын паспорттай/-д 2018.05.10-ны өдөр нэг удаагийн, "Н" ангиллын 90 хоногийн байх хугацаатай виз олгохдоо визийн хүчинтэй хугацааг алдаатай буюу 91 хоногоор олгосныг илрүүлэн, 90 болгон засварлаж, визийн тэмдгээр баталгаажуулсан.

Польш Улсын 2 иргэн /Jankowski Adam Marek, 1984.11.24-нд төрсөн, эрэгтэй, EL1586476 дугаарын паспорттай, Miniszewska Emelina Magdalena 1986.08.30-нд төрсөн, эмэгтэй, EM0624396 дугаарын паспорттай/-д Монгол Улсаас Австри Улсын Вена хотод суугаа ЭСЯ-наас нэг удаагийн J ангиллын виз олгохдоо визийн хүчинтэй хугацааг 91 хоногоор олгосныг илрүүлэн 90 хоног болгон засварлаж, визийн тэмдэг дарж баталгаажуулсан. Мөн Magdalena гэсэн нэрийг визэнд бичээгүй байсныг нөхөж бичиж визийн тэмдгээр баталгаажуулсан.

ОХУ-ын 1 иргэн Balabanovich Igor /1956.07.09, эрэгтэй, 757561734 дугаарын паспорттой/-д Монгол Улсаас ОХУ-ын Москва хотод суугаа ЭСЯ-наас В ангиллын нэг удаагийн орох виз олгохдоо визийн хүчинтэй хугацааг 91 хоногоор олгосныг илрүүлэн 90 хоног болгон засаж, визийн тэмдэг дарж баталгаажуулсан.

Прага хот дахь Монгол Улсын ЭСЯ-наас Чех Улсын 4 иргэнд олгосон J ангиллын нэг удаагийн орох визийн хүчинтэй хугацаа 91 хоногоор буруу олгосныг засварлан, визийн тэмдгээр баталгаажуулан улсын хил нэвтрүүлсэн болно.

БНКазУ-ын иргэн Хуаныш Октябрь эрэгтэй Астана хотод суух Монгол Улсын ЭСЯ-наас олгосон Н ангиллын нэг удаагийн орох визийн хүчинтэй хугацаа 91 хоног

гэж буруу бичсэн байсныг 90 хоног болгон засварлаж визийн тэмдгээр баталгаажуулсан.

ИБУИНВУ-ын 2 иргэн /Mulligan Ryan Kyle 1988.06.24, эрэгтэй, 538838577 дугаарын гадаад паспорттай, Joynes Charlotte Rose 1989.05.29, эмэгтэй, дугаарын гадаад паспорттай/-д БНКазУ-ын Алмата хот дахь Монгол Улсын ЭСЯ-наас J ангиллын нэг удаагийн орох виз олгохдоо визийн хүчинтэй хугацааг 91 хоногоор олгосныг илрүүлэн 90 хоног болгон засаж, визийн тэмдэг дарж баталгаажуулсан.

**Хил орчмын зорчих үнэмлэхээр зорчигч гадаадын иргэдийн бүртгэл, хасалтын талаар:**

Хил орчмын нутаг дэвсгэрт зорчих үнэмлэхээр зорчигч БНХАУ-ын 2 иргэнд бүртгэл хасалт хийж хяналт тавьж ажилласан.

**Түр ирэгчийн бүртгэл, хасалтын талаар:**

БНКаз.У-ын 122, БНХАУ-ын 139, ОХУ-ын 1 иргэн, нийт 262 гадаадын иргэнийг түр ирэгчээр бүртгэж, БНКазУ-ын 119 гадаадын иргэний Монгол Улсад байх хугацааг 90 хоногоор хасалт хийсэн.

**Гадаадын иргэнд визийн зөвшөөрлийн талаар:**

“Ховдын өргөө” ХХК-ний ирүүлсэн виз хүссэн материалын бүрдлийг хангуулж илтгэх хуудсаар Виз зөвшөөрлийн газарт хүргүүлсэн.

Хувийн урилга хүссэн Монгол Улсын 3 иргэний 3 гадаадын материалыг хүлээн авч шалган хүсэлтийг Виз зөвшөөрлийн газарт хүргүүлсэн.

**Гадаадын иргэн оршин суух бүртгэл хасалтын чиглэлээр:**

Монгол Улсад хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл шинээр авах хүсэлт гаргасан БНКаз.Улсын 4 иргэний холбогдох өргөдөл материалыг хүлээн авч, хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр Төвд хүргүүлсэн.

Тайлангийн хугацаанд нийт БНКаз.У-ын 6 иргэнд оршин суух үнэмлэх тараасан.

Монгол улсад хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл хүссэн БНКаз.Улсын 2, БНХАУ-ын 43 иргэний хурууны хээг авч баталгаажуулан, Мэдээлэл технологийн хэлтэст онлайнаар хүргүүлсэн.

Монгол улсад хувийн хэргээр оршин суух зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлт гаргасан БНКаз.Улсын 1 иргэний холбогдох өргөдөл материалыг хүлээн авч, хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр Төвд хүргүүлсэн.

Монгол Улсад хувийн хэргээр оршин суух зөвшөөрөлтэй БНКаз.У-ын 17 иргэний хувийн хэрэгт баяжилт хийсэн болно.

Оршин суух хасалт хийлгэн эх орондоо 24 гадаадын иргэн буцсан байна.

## **1.2. Гадаадын иргэдэд тавих хяналт шалгалтын хүрээнд:**

ТЕГ-ын Ховд аймаг дахь газар болон ГИХГ-ын Баруун бүс дэх газрын даргын хамтарсан 2018 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн ББ-2018/15-06 тоот тушаалаар Ховд аймгийн нутаг дэвсгэрт албан болон хувийн хэргээр оршин сууж буй гадаадын иргэдийн хөдөлмөр эрхлэлт, оршин суух зөвшөөрөл нь хууль тогтоомжид нийцэж буй эсэх, МУ-д ирсэн зорилгоосоо өөр үйл ажиллагаа явуулж буй гадаадын иргэдийг илрүүлж холбогдох хууль тогтоомжуудыг хангуулах зорилготой хийсэн шалгалтад нийт 2 аж ахуйн нэгжийн 289 гадаадын иргэн хамрагдсан.

### **Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын хүрээнд:**

Гадаадын иргэн, харьяатын газрын Баруун бүс дэх газрын даргын 2018 оны 04 дүгээр сарын 19-ны өдрийн ББ-2018/15-05 тоот хяналт шалгалт хийх удирдамжийн дагуу Ховд аймагт Хяналтын улсын ахлах байцаагч А.Булгантамир, Хяналтын улсын байцаагч Б.Бат-Өлзий, Б.Номинчимэг, жолооч Б.Баянмөнх, Говь-Алтай, Завхан, Баянхонгор аймагт Хяналтын улсын байцаагч Т.Баяржаргал, Н.Насанбуян, Г.Буянжаргал, жолооч Б.Нямдорж, Увс аймагт Хяналтын улсын байцаагч Х.Адъяа, мэргэжилтэн В.Энхтайван нарын бүрэлдэхүүнтэй бүлэг тус аймгуудийн нутаг дэвсгэрт уул уурхай ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжүүдэд ажиллаж байгаа гадаадын иргэдэд 2018 оны 04 дүгээр сарын 19-нөөс 04 дүгээр сарын 30-ны хооронд төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгуулж явууллаа. Шалгалтанд 13 аж ахуйн нэгжийн 9 орны 47 гадаадын иргэн хамрагдсан.

ГИХГ-ын даргын 2018 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн №01/04/06 дугаарын удирдамжийн хүрээнд Ховд, Баян-Өлгий, Завхан аймгуудад үйл ажиллагаа явуулж буй олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газарт хяналт шалгалт хийсэн. Ховд аймгийн Норвегид төвтэй "НЛМ" байгууллага, "Жи Си Эс" байгууллагуудад Хяналтын улсын ахлах байцаагч А.Булгантамир, мэргэжилтэн Ц.Одгэрэл, жолооч Б.Баянмөнх нар 2018 оны 05 дугаар сарын 17-ны өдөр, Норвегид төвтэй "НЛМ" байгууллагын Баян-Өлгий аймаг дахь салбарт тус Хэлтсийн дарга Д.Мягмаржав, виз зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн, хяналтын улсын байцаагч Г.Батцэцэг, жолооч Ч.Едик нар 2018 оны 05 дугаар сарын 19-ний өдөр хяналт шалгалт хийсэн. Шалгалтанд 3 аж ахуйн нэгж байгууллагын 15 гадаадын иргэн хамрагдсан бөгөөд илэрсэн зөрчилгүй. Шалгалтын үр дүнг илтгэх хуудсаар Хяналт шалгалтын газарт хүргүүлсэн.

Боомт, орон нутгийн хэлтсийн даргын 2018 оны 5 дугаар сарын 02-ны өдөр 11/985 тоот албан бичгээр ирүүлсэн үүргийн хүрээнд Бүсийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй шашины байгууллага, сүм хийдийн судалгаа гаргаж Боомт орон нутгийн хэлтэст хүргүүлсэн.

### **Гадаадын иргэний зөрчил, түүний шийдвэрлэлтийн хүрээнд:**

**Бүсийн төвд:** Визийн байх хугацааг 1954 хоног хэтрүүлсэн БНКаз.Улсын 1 иргэнийг Зөрчлийн тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт зааснаар 2 000 000 төгрөгөөр торгож шийтгэл ногдуулсан.

**Булган боомт:** Визийн байх хугацаа хэтрүүлсэн БНХАУ-ын 1 иргэнийг Зөрчлийн тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт зааснаар 150 000 төгрөгөөр торгож шийтгэл ногдуулсан.

**Баян-Өлгий аймагт:** Визийн хугацаа 38 хоног хэтрүүлсэн БНКаз.У-ын 1 иргэнийг Зөрчлийн тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт зааснаар 380.000 төгрөгөөр, визийн хугацааг 15 жилээр хэтрүүлсэн БНКаз.У-ын 1 иргэнийг Зөрчлийн тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт зааснаар 2.000.000 төгрөгөөр тус тус торгож, шийтгэл хүлээлгэсэн.

**Цагааннуур боомтод:** Бүртгэлийн талаар тогтсон журам зөрчсөн БНКаз. Улсын 1 иргэнийг Зөрчлийн тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэгт зааснаар 100.000 төгрөгөөр торгож, шийтгэл хүлээлгэсэн.

Визийн хугацаа хэтрүүлсэн зөрчил гаргасан БНКаз.У-ын 2 иргэн Зөрчлийн тухай хуулийн шийтгэл хүлээх нас буюу 16 нас хүрээгүй тул гомдол мэдээлэл хүлээн авахаас татгалзан, зөрчлөөс чөлөөлж шийдвэрлэсэн.

### **Гадаадын иргэн Монгол Улсаас албадан гаргасан талаар:**

Визийн хугацаа хэтрүүлсэн БНКаз.У-ын 1 иргэнийг ГИХГ-ын даргад хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр танилцуулж, Монгол Улсаас албадан гаргах арга хэмжээнээс чөлөөлүүлж шийдвэрлэсэн бөгөөд дээрх иргэн нь Цагааннуур боомтоор эх орондоо буцсан.

### **Хил дээрээс буцаасан гадаадын иргэн:**

"Оюун далай цаг" ХХК-д хөдөлмөр эрхлэхээр ирсэн БНХАУ-ын НГ ангиллын визтэй 8 иргэнийг Булган боомтоор хасалт хийлгэн гарахаар ирсэн боловч уг компаний албан хүсэлт байхгүй байсан тул хил нэвтрүүлэлгүй буцаасан.

Булган боомтоор хил нэвтрэхээр ирсэн БНХАУ-ын МА HUELIANG /J46423634 паспортын дугаартай эрэгтэй/ тулгай тэмдэглэлтэй байсан тул хил дээрээс буцаасан.

Цагааннуур боомтоор хил нэвтрэхээр ирсэн Азербайжан Улсын 1 иргэн Монгол Улсад байх, буцаж явах хөрөнгийн эх үүсвэрийн баталгаагүй гэсэн үндэслэлээр Монгол Улсын хил нэвтрүүлэлгүй буцаасан.

Цагааннуур боомтоор хил нэвтрэхээр ирсэн Украин улсын 1 иргэнийг уригчгүй учир Монгол Улсын хил нэвтрүүлэхгүй буцаасан.

### **1.3. Иргэний харьяаллын асуудлын хүрээнд:**

Виз бүртгэл, оршин суух журам болон харьяатын чиглэлээр нийт 235 хүнд зөвлөгөө өгсөн.

Иргэний харьяаллын чиглэлээр лавлагаа хүссэн 20 өргөдөл хүлээн авч, холбогдох лавлагааг олгосон.

Монгол улсын харьяатаас гарах 2 өрхийн 6 иргэн, Монгол Улсын харьяалал сэргээн тогтоолгох 1 өрхийн 2 иргэний материалын бүрдлийг хангуулж, арга зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлсэн.

## **ХОЁР. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР:**

### **2.1. Тушаал төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн чиглэлээр:**

Тайлант хугацаанд тус газрын дарга тушаал гаргаагүй ба тус газар 2018 оны тавдугаар сард хийх ажлын төлөвлөгөөнд нийт 31 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж төлөвлөгөөний биелэлт 100 хувьтай хэрэгжсэн.

Төвөөс өгсөн үүргийн дагуу тус газрын үндсэн үйл ажиллагааны талаарх хоногийн мэдээг гаргаж өдөр бүр, инфографик мэдээнд тусгах Баруун бүс дэх газрын статистик тоон мэдээг өмнөх оны мөн үетэй харьцуулан гаргаж тухай бүр Боомт, орон нутгийн хэлтэст хүргүүлсэн.

Бүсийн газрын нийт 12 албан хаагчид хувийн тэмдэг эзэмшүүлэх саналаа Боомт, орон нутгийн хэлтэст хүргүүлсэн.

### **2.2. Хүний нөөц, сургалтын чиглэлээр:**

Байгууллагын даргын 2017 оны Б/51 дүгээр тушаалаар тус газрын батлагдсан орон тоо 42 бөгөөд одоо ажиллаж байгаа 37 албан хаагч үүрэг гүйцэтгэж байна. Үүнээс байгууллагын даргын тушаалаар 3 албан хаагч сургалтын чөлөөтэй. Бүсийн газрын 2018 оны ээлжийн амралтын хуваарийн дагуу 4 албан хаагч ээлжийн амралтаа эдэлж байна.

Байгууллагын даргын 2018 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн А/155 дугаар тушаалд заасны дагуу 3 албан хаагчаар төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргүүлсэн.

Байгууллагын даргын 2018 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн Б/146 тоот тушаалаар 1 албан хаагч ажлаас чөлөөлөгдөж, 2018 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн Б/160 тоот тушаалаар 1 албан хаагч шилжсэн. Ажлаас чөлөөлөгдсөн болон шилжсэн албан хаагчидтай ажил хүлээлцэх ажлыг зохион байгуулсан.

Тамгын газраас бүсийн газрын нийт албан хаагчдын гэр бүлийн гишүүний ажил эрхлэлт, хүүхдийн талаар, Хяналтын улсын байцаагчийн эрх олгох сургалтанд хамрагдах албан хаагчийн талаар, 2018 оны 06 дугаар сард Зүүн бүсэд зохион байгуулагдах “Хяналтын улсын байцаагч нарын нэгдсэн” цугларалтанд оролцох албан хаагчдын нэрсийг, Боомт орон нутгийн хэлтсээс Бүсийн газрын албан хаагчдын гэр бүлийн байдал талаархи дэлгэрэнгүй судалгааг тус тус гарган өгсөн.

Төрийн дээд одон медаль, Хууль зүйн яамны шагналд нэр дэвшүүлэх албан хаагчийн судалгааг гарган анкет тодорхойлолтын хамт Тамгын газарт хүргүүлсэн.

Бүсийн газрын нийт албан хаагчдад шинэ энгэрийн четон тараан өгч, хуучин энгэрийн четоныг хураан авсан.

2018 оны 05 дугаар сарын 03-ны өдөр Ховд аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтсийн мэргэжилтэн С.Цэцэгсүрэн “Авилгалын тухай хууль”, “Ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн талаар, 2018 оны 05 дугаар сарын 21-ний өдөр Ховд аймгийн цагдаагийн газрын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тасгийн ахлах дэслэгч Ж.Оронбасар “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай

хууль”-ийн шинэчилсэн найруулга, “Архины хор хөнөөл, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль”-ийн талаар албан хаагчдад сургалт зохион байгуулсан.

2018 оны 05 дугаар сарын 07-ны өдөр “Гадаадын иргэн харьяатын газрын албан хаагчдын дүрэмт хувцас өмсөх” журмаар нярав Э.Алтантунгалаг, 2018 оны 05 дугаар сарын 14-ний өдөр “Байгууллагын мэдээллийн технологийн үйл ажиллагааны журам”-аар сүлжээний инженер Б.Даваапүрэв, “Эмнэлэгийн анхан шатны тусламж үзүүлэх талаар” сэдвээр Баян-Өлгий аймаг дахь хэлтсийн жижүүр Г.Нарантуяа, “Байгууллагын аюулгүй байдлыг хангахад анхаарах асуудал” сэдвээр виз зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн Г.Батцэцэг, “Гэр бүлийн хүчирхийллийн тухай хуулийн шинэчилсэн найруулга” сэдвээр мэргэжилтэн С.Гүлбану нар сургалт явуулсан.

2018 оны 05 дугаар сарын 10-ны өдөр Ховд аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагааны хяналт шинжилгээ, үнэлгээ хийх чадавхыг бэхжүүлэх нь” сэдэвт сургалтанд тус газрын 4 албан хаагч хамрагдаж мэдлэг ур чадвараа дээшлүүлсэн.

### **2.3. Уулзалт, хурал цуглаанд оролцсон талаар:**

Долоо хоногийн “Даваа” гараг бүр албаны зөвөлгөөн хийж өнгөрсөн 7 хоногт хийсэн ажлаа тайлагнан, ирэх 7 хоногт хийж гүйцэтгэх ажлаа төлөвлөж хэлтсүүдийн үйл ажиллагааны уялдааг сайжруулан ажилласан.

Газрын дарга сар бүрийн 1, 3 дахь 7 хоногийн Мягмар гаригийн 10 цагаас Ховд аймгийн Засаг даргын шуурхай зөвлөгөөнд 3 удаа, Баян-Өлгий, Говь-Алтай аймаг дахь хэлтсийн дарга нар, Увс аймаг дахь төлөөллүүд 7 хоног бүрийн аймгийн шуурхай хуралд тус тус оролцсон.

Монгол Улсын Ерөнхийлөгч 2018 оны 05 дугаар сарын 05-06-ны өдрүүдэд Баруун аймгуудад ажиллаж аймгийн ард иргэд, удирдлагуудтай уулзах уулзалтанд Бүсийн төв, Баян-Өлгий аймаг дахь хэлтсийн нийт албан хаагчид оролцсон.

2018 оны 05 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд сүлжээний инженер Б.Даваапүрэв, Б.Одбаяр нар “Инженерүүдийн мэргэжил арга зүйн цугларалтанд” оролцож мэдлэг чадвараа дээшлүүлэн ашиглагдаж буй программ хангамж, хийгдэж байгаа ажлын талаар харилцан туршлага солилцсон.

2018 оны 05 дугаар сарын 22-ны өдөр Ховд аймгийн Цагдаагийн газраас зохион байгуулсан “Гэрч, хохирогчийг хамгаалах туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр”, “Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангахад тулгамдаж буй асуудал, бэрхшээлийг шийдвэрлэх тухай нээлттэй хэлэлцүүлэгт тус газрын хяналтын улсын байцаагч Б.Номинчимэг оролцож санал хүсэлтээ солилцсон.

2018 оны 05 дугаар сарын 24-нд Баян-Өлгий аймаг дахь Цагдаагийн газраас зохион байгуулсан “Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт, тулгамдаж буй хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга зам, төрийн болон төрийн бус байгууллагуудын харилцан уялдааг сайжруулах нь” сэдвээр зохион байгуулсан хэлэлцүүлэгт тус Хэлтсийн дарга Д.Мягмаржав оролцсон.

#### **2.4. Өргөдөл, гомдол, архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр:**

Баруун бүс дэх газарт 2018 оны 05 дугаар сард албан хаагчдаас 7 өргөдлийг хүлээн авч 5 өргөдлийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэсэн. 2 өргөдөл шийдвэрлэлтийн шатандаа явж байна.

Тайлангийн хугацаанд Бүсийн газарт ирсэн 15 албан бичгийг удирдлагад танилцуулан бүртгэн, холбогдох албан тушаалтанд шилжүүлж, 14 албан бичгийг боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж ажилласан.

#### **2.5. Мэдээллийн технологийн чиглэлээр:**

2018 оны 05 дугаар сарын 05-06-ны өдрүүдэд Баян-Өлгий аймаг дахь хэлтэст ажиллаж хэлсийн төв, Цагааннуур, Даян боомтуудад албан хэрэгцээнд ашиглаж буй 11 компьютерийг форматласан.

Шинээр батлагдсан байгууллагын мэдээллийн технологийн үйл ажиллагааны журмын дагуу Immigration wifi сүлжээг хааж, дотоод сүлжээ болон интернэт сүлжээний IP хаягийн бүртгэлийг хийж IP хаягийн хэрэглэгч бүр дээр гараар тохируулах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Нээлттэй хаалганы өдөрлөгт зориулан 7 төрлийн 210 ширхэг боршур, тараах материалыг өнгөтөөр хэвлэн, 1 ширхэг сурталчилгааны самбарын эхийг бэлтгэн хэвлүүлсэн.

#### **2.6 Санхүү, хөрөнгө оруулалт, хангамжийн чиглэлээр:**

Тайлант хугацаанд батлагдсан төсвийг зохих зардлын дагуу зарцуулан өр, авлагагүй ажилласан.

Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, үнэт цаас болон хүү торгууль, улсын тэмдэгтийн хураамжийн тайланг энэ оны 05 дугаар сарын 02-ны дотор гарган, хүү торгууль 200,000 төгрөг, тэмдэгтийн хураамж 30 384 000 төгрөгөөр тайланг нэгтгэн Хяналтын улсын байцаагч нартай тооцоо нийлж Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэст хүргүүлсэн.

2018 оны 05 дугаар сард 241.8 сая төгрөгийн урсгал санхүүжилт орсоноос нийт зарлага 194.3 сая төгрөгийн дүнгээр тайлагнав.

Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг гарган 2018 оны 05 дугаар сарын 05-ны дотор Нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлсэн ба ХАОАТ-ын тайлан, цалин хөлснөөс суутгасан ашгийн тайланг мөн сарын 15-ны өдөр гарган Ховд аймгийн татварт хүргүүлэн тооцоо нийлж ажилласан.

Албан хаагчдад үнэт цаасыг шаардах хуудасны дагуу олгосон ба авто машины ашиглалт болон шатах тослох материалын тооцоог жолооч нартай тооцоо нийлэн дэвтэрт бичилтийг хийж бүртгэл хөтөлсөн.

Шуудан, холбоо болон интернетийн төлбөрт 1 418 500 төгрөг, байрны түрээсийн зардалд 1 340 000 төгрөгийг харилцагч байгууллагын нэхэмжлэхийн дагуу цаг хугацаанд нь холбогдох данс руу шилжүүлээ.

Тус газар төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтын ил тод байдлыг ханган ажиллаж Баруун бүс дэх газрын санхүүгийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл, шилэн дансны мэдээллийг 2018 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн дотор байршуулан ажилласан.

Албан хаагчдаас ирүүлсэн шаардах хуудасны дагуу 100500 төгрөгний бичиг хэргийн материал, 36000 төгрөгний аж ахуй материалын татан авалт хийгдсэн.

Боомт орон нутгийн хэлтсийн даргаас ирүүлсэн үүргийн дагуу төвөөс ирүүлсэн байцаагчийн 16 ширхэг цүнх, 2 төрлийн 18 ширхэг номыг боомт бүр дээр тараан өгсөн.

## **2.7. Бусад хийгдсэн ажлууд:**

Ховд аймгийн Прокурорын газраас 2018 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр Ховд аймагт зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллагуудын дунд зохион байгуулсан “Дэвжээ” тэмцээнд Ховд аймгийн Нийгмийн даатгалын газартай хамтран оролцож 4 дүгээр байр эзэлсэн амжилт гаргасан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлигийн дагуу 2018 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Бүсийн газрын нийт албан хаагчид хариуцсан талбайд мод тарьсан.

2018 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Бүсийн төвийн албан хаагчид Буянт суманд байрлах 1 га ногооны талбайд очин өргөн хэрэглээний хүнсний ногоо тариалсан.

2018 оны 05 дугаар сарын 19-ний өдөр Ховд аймгийн Жаргалант сум, Ховд аймгийн Биеийн тамир спортын газраас зохион байгуулсан “Эртэч Ховдчууд-Эрч хүч идэвхитэй амьдрал” бүх явган аялалд бүсийн төвийн 11 албан хаагч хамрагдаж хувцас жигдрэлтээр тэргүүн байр эзэлсэн.

Говь-Алтай аймаг дахь хэлтэс нь Албаны байр барих зориулалтаар Говь-Алтай аймгийн Засаг даргын 2018 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/161 дугаар Говь-Алтай аймгийн Есөнбулаг сум /төв/-ын Баянхайрхан багт 600 м2 газрыг 15 жилийн хугацаатай эзэмших эрхийн захирамж гаргуулан авсан.

Баян-Өлгий аймаг дахь хэлтсийн гадна талбайд 2 ширхэг цэцгийн мандал хийсэн.

2018 оны 05 дугаар сарын 12-ны өдөр буюу Бямба гарагт Баян-Өлгий аймаг дахь хэлтсийн нийт албан хаагчид Цагааннуур боомтод ажиллаж, тус боомт дахь ажилтны амьдрах байранд засвар, тохижилтын ажил хийж гүйцэтгэсэн.

2018 оны 05 дугаар сарын 23-ны өдөр Бүсийн төвийн албаны байрны гадна талбайд “Нээлттэй хаалганы өдөрлөг” зохион байгуулж Ховд аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтсийн дарга Б.Мөнхбат, Ховд аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын дарга Л.Билэгдэмбэрэл, Ховд аймгийн Жаргалант сумын Засаг даргын орлогч Ц.Лувсанлхамо нар урилгаар, Төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, хувийн хэргээр оршин сууж буй гадаадын иргэн зэрэг 80 гаруй иргэд идэвхитэй оролцон өөрсдийн сонирхсон чиглэлээр асуулт асуун



нээлттэй ярилцан мэдээлэл солилцсон. Уг арга хэмжээг Ховд аймгийн Олон ястан телевиз сурвалжлан мэдээ бэлтгэн ард иргэдэд сурталчилан ажиллаа.

Увс аймгийн Хяргас суманд 2018 оны 04 дүгээр сарын 27-нд “Байгууллагын нэг өдөр”-ийг зохион байгуулж мэргэжилтэн В.Энхтайван байгууллагын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны талаар иргэдэд мэдээлэл олгож, танилцуулга, гарын авлагыг тараасан.